



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/214

Улаанбаатар хот

Онцгой амжилт гаргасан багшийг
шагнаж урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.6 дахь заалт, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны А/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны А/26 дугаар тогтоолоор баталсан шалгуур үзүүлэлтийг хангаж Нийслэлийн ерөнхий боловсролын багш нарын ур чадварын тэмцээнд амжилттай оролцсон багшийг шагнаж урамшуулсугай.

2. Шагналд шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Шагналд зарцуулагдах 660,000 (Зургаан зуун жаран мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны..... сарын..... ны өдрийн..... дугаар
захирамжийн хавсралт



ШАГНАЛД ЗАРЦУУЛАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Урамшуулал олгох сурагчийн нэр	Хэмжих нэгж	Гаргасан амжилтын тоо	Нэгж үнэ	Бүгд үнэ
Башийн амжилт					
1.	Р.Болортуяа	хүн	1	600,000	600,000
2.	Өргөмжлөл	ш	1	60,000	60,000
Дүн					660,0000